

Хувьцаа эзэмшигчдийн хурлын  
2023 оны 4 сарын 28-ны өдрийн 05 дугаар  
тогтоолын хавсралт

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” НЭЭЛТТЭЙ  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ  
/Шинэчилсэн найруулга/

СААТАР ХОТ  
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН АЭРЭГЖҮҮЛСГЧ АГЕНТСЛЭГ

УЛСЫН БҮРТГӨЛСНИЙ ЕРОНХИМ ГАЗАР

УЛСЫН БҮРТГӨГЧ 570

Хувьцаатуулсын улсын бүртгэлийн  
нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл 9007001016

2023 оны 08 сарын 30

Бүртгэсэн: Улсын (яхлах) бүртгэтийн

- Дүрмийн зорилго, компанийн эрх зүйн байдал**
1. Энэхүү дүрмийн зорилт нь “Монголын хөрөнгийн бирж” нээлттэй хувьцаат компанийн /цаашид “Компани” гэх-/ийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, хяналтын бүтэц, тэдгээрийн эрх, үргийг тодорхойлоход оршино.
  2. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэл гаргадаг, банканд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээдэг, тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө хуулийн этгээд мөн. Компани өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгтэй байж болох бөгөөд түүний загварыг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ баталж, Оюуны өмчийн газар бүртгүүлнэ.
  3. Компани нь өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, оноосон нэр бүхий тэмдэгтэй байна.
  4. Компани нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.
  5. Компани үйл ажиллагаандaa нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, компанийн засаглалын шилдэг жишигийг удирдлага болгоно.
  6. Энэхүү дүрмийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид үндэслэн боловсруулсан бөгөөд хожим хууль, тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлт нь дүрмийн хэсэг, зүйл, заалттай зөрчилдөх тохиолдолд хуулийн зохицуулалтыг мөрдөх бөгөөд шаардлагатай тохиолдолд дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
  7. Компанийн дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.
  8. Компани нь төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани бөгөөд төрийн өмчийн төлөөлөл буюу хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь Засгийн газраас эрх олгосны дагуу Сангийн яам байна<sup>1</sup>.
  9. Компани Монгол Улс болон гадаадад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхгүй болно.

**Оноосон нэр, хаяг**

10. Компанийн оноосон нэрийг Монгол хэлээр “Монголын хөрөнгийн бирж” ХК, Англи хэлээр “Mongolian Stock Exchange” JSC буюу товчоор “MSE” гэнэ. Компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд оноосон нэрийнхээ дараа “ХК” гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.
11. Компанийн төв байрны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Сүхбаатарын талбай 3 болно.

Утас, Факс: 11-310506

Цахим шуудан: info@mse.mn

Цахим хаяг: www.mse.mn

<sup>1</sup> Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 152 дугаар тогтоол

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. КОМПАНИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ХУГАЦАА

2.1. Компанийн эрхэм зорилго нь үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг сэргээн хөгжүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, дэмжин урамшуулахад үйл ажиллагаагаа чиглүүлж, үнэт цаасны зах зээлийг сонгодог утгаар нь төлөвшүүлэн хөгжүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг нээлттэй ил тод зохион байгуулахад оршино.

*/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

2.2. Компанийн үйл ажиллагаа нь үнэт цаасны зах зээлд үнэт цаасны болон уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа эрхлэх, тооцооны болон өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагаа, хуулиар зөвшөөрсөн бусад арилжаа, эрхлэхэд чиглэсэн байна.

*/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

2.3. Компани нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан зохицуулалттай этгээд болох арилжаа эрхлэх, болон өөрийгөө зохицуулах байгууллагын хувьд, мөн Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг гүйцэтгэгчийн хувьд хуульд заасан дүрэм, журмыг баталж мөрдүүлэх, арилжаа зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

*/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

2.4. Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсний үндсэн дээр тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.

2.5. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

### ГУРАВДУГААР БҮЛЭГ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

#### **Хувь нийлүүлсэн хөрөнгө**

3.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь компанийн нийт гаргасан эргэлтэд байгаа хувьцаанаас бүрдэх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгөнд зарласан болон эргүүлэн худалдан авсан халаасны хувьцаа хамаарахгүй.

3.2. Компани нь нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 350,463,539 (гурван зуун тавин сая дервөн зуун жааран гурван мянга таван зуун гучин ес) ширхэг энгийн хувьцаатай буюу нийт 35,046,353,900 (гучин таван тэрбум дөчин зургаан сая гурван зуун тавин гурван мянга есөн зуу) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.

3.3. Компанийн хувьцаа эзэмшигчид нь дараах байдлаар компанийн хувьцааг эзэмшинэ:

№	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны			Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн
		Нэрлэсэн үнэ	Тоо ширхэг	Эзэмшлийн хувь	
1	Төр	100 төг	231,305,936	66 хувь	23,130,593,600
2	Олон нийт	100 төг	119,157,603	34 хувь	11,915,760,300
	Нийт	100 төг	350,463,539	100 хувь	35,046,353,900

3.4. Компанийн энгийн хувьцаа нэг бүр нь нэг саналын эрхтэй байна. Хувьцаа нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд аливаа эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.

#### **Өөрийн хөрөнгө**

3.5. Компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс компанийн нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө гэнэ.

3.6. Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд уг нөхцөл байдал бүртгэгдсэн албан ёсны санхүүгийн тайлан гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор ТУЗ Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаж, хувь нийлүүлсэн хөрөнгөнд өөрчлөлт оруулах, компанийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл татан буулгах асуудлыг шийдвэрлүүлнэ.

#### **Компанийн хувьцаа эзэмшигч**

3.7. Хуулиар хориглоогүй бол хувьцаа эзэмшигчид нь хувь хүн, хуулийн этгээд байна.

3.8. Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг үнэт цасны хадгаламж, бүртгэлийн эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

#### **Компанийн болон хувьцаа эзэмшигчдийн хариуцлага**

3.9. Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.

3.10. Компани нь Хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд Хувьцаа эзэмшигч нь Компанийн хүлээх үүргийг хариуцахгүй.

3.11. Компанийн хувьцаа эзэмшигчид нь гагцхүү өөрийн эзэмшиж буй хувьцааныхаа хэмжээгээр эрсдэл, хариуцлага хүлээнэ.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**

#### **Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний зарлан хуралдуулах**

4.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

4.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байх бөгөөд ээлжит хурлыг ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан хугацаанд буюу санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор жилд нэг удаа зарлан хуралдуулна.

4.3. Дараах тохиолдолд ТУЗ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна:

4.3.1. ТУЗ-ийн нийт гишүүний 50-иас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;

4.3.2. ТУЗ-ийн хоёр болон түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 болон түүнээс дээш хувийн хувьцааг дангаар эзэмшигч санал, шаардлага гаргасан;

4.3.3. компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;

4.3.4. Аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;

4.3.5. ТУЗ шаардлагатай гэж үзэж шийдвэр гаргасан;

4.3.6. Компанийн тухай хууль болон дүрэмд заасан бусад тохиолдол.

4.4. Хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах зүйлийг заана:

4.4.1. хурал хуралдуулах газар, өдөр, цаг;

4.4.2. хурлын хэлэлцэх асуудал;

4.4.3. хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;

4.4.4. хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам;

4.4.5. хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт;



- 4.4.6. саналын хуудсаар санал авах бол тухайн саналын хуудасны агуулга;
  - 4.4.7. саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр;
  - 4.4.8. хурлын дарга;
  - 4.4.9. тооллогын комиссын дарга, гишүүд.
- 4.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна.
- 4.6. Компани хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ.
- 4.7. Хурлын зард дараах зүйлийг тусгана:
- 4.7.1. компанийн оноосон нэр, байршил;
  - 4.7.2. хурал хийх өдөр, цаг, газар;
  - 4.7.3. бүртгэлийн өдөр;
  - 4.7.4. хурлаар хэлэлцэх асуудал, шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам.

#### **Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх**

- 4.8. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх бүрэн эрхтэй. Үүнд:
- 4.8.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
  - 4.8.2. нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
  - 4.8.3. компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
  - 4.8.4. компанийн хэлбэрийг өөрчлөх;
  - 4.8.5. компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
  - 4.8.6. хувьцааг хуваах, эсвэл нэгтгэх;
  - 4.8.7. ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
  - 4.8.8. Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх;
  - 4.8.9. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
  - 4.8.10. ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;
  - 4.8.11. ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
  - 4.8.12. хуульд заасны дагуу компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;
  - 4.8.13. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
  - 4.8.14. компанийн зорилтот түвшинг батлах;

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор нэмж оруулсан/

- 4.8.15. ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
- 4.8.16. хувьцаагаа үнэт цаасны хадгаламжийн байгууллагын бүртгэлээс хасуулах асуудал;
- 4.8.17. хууль тогтоомжид заасан бусад.

## **Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох**

- 4.9. Дараах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхиор батална. Үүнд:
- 4.9.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг батлах;
  - 4.9.2. нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
  - 4.9.3. компанийн хэлбэрийг өөрчлөх;
  - 4.9.4. компанийн өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох;
  - 4.9.5. давуу эрхийн хувьцаа гаргах;
  - 4.9.6. компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
  - 4.9.7. хувьцааг хуваах, эсвэл нэгтгэх;
  - 4.9.8. хувьцааг тэргүүн эзлжинд худалдан авах эрхийг здлүүлэх эсэх;
  - 4.9.9. энэхүү дүрмийн долдуугаар бүлэгт заасан Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг батлах, хяналтын зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, чөлөөлөх, Хяналтын зөвлөлийн гишүүний цалинг тогтоох;
  - 4.9.10. Хяналтын зөвлөлийн жилийн үйл ажиллагааны тайлантай танилцах, хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар Хяналтын зөвлөлөөс ирүүлсэн санал, хүсэлтийг зохих журмын дагуу шийдвэрлэх;
  - 4.9.11. хууль болон энэхүү дүрэмд заасан бусад асуудал.
- 4.10. Энэхүү дүрмийн 4.9-д заасан болон ТУЗ-ийн гишүүдийг сонгохоос бусад асуудлаар гаргах шийдвэр нь хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын олонхи дэмжсэнээр хүчин төгөлдөр болно.
- 4.11. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ. Энэ аргыг хэрэглэхдээ Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмыг баримтална.
- 4.12. Хувьцаа эзэмшигч нь ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй хүнд тус тусад нь санал өгнө. Энэ тухай зааврыг Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны журмыг баримтлан тухайн хурлын санал авах хуудсанд тусгана.
- 4.13. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тоолоходоо тус бүрд нь тоолж, хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр тус тус сонгоно.

### **Хуралд оролцох журам**

- 4.14. Хувьцаа эзэмшигч нь иргэний үнэмлэхтэйгээ ирж, үнэт цаасны тевлэрсэн хадгаламжийн байгууллагаас бүртгэлийн өдрөөр тодорхойлсон хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган бүртгүүлж хуралд оролцно. Хэрэв хуралд биеэр оролцох боломжгүй бол өөрийгөө төлөөлүүлж хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох этгээдэд нотариатаар гэрчлүүлсэн итгэмжлэлийн үндсэн дээр оролцуулж болно.
- 4.15. Төлөөлөх тухай итгэмжлэл нь тодорхой хугацаа заагаагүй бол гагцхүү тухайн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүчинтэй байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл хойшлогдсон хуралд хүчинтэй хэвээр байна.
- 4.16. Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирүүлсэн саналын хуудас, мөн хувьцаа эзэмшигчийн итгэмжлэлийг хурлыг зарласан өдрөөс эхлэн хурал хуралдах өдрийн хурал эхлэх цаг хүртэл хүлээн авч бүртгэнэ. Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг энэхүү дүрэмд зааснаар тогтоосон бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тодорхойлж, тооллогын комисс, эсхүл түүний үүргийг гүйцэтгэхээр ТУЗ-өөс тусгайлан томилсон этгээд гүйцэтгэнэ.
- 4.17. Хувьцаа эзэмшигчид нь хэлэлцэж буй асуудлын талаар саналаа санал авах худсаар ирүүлсэн тохиолдолд түүнийг тухайн хуралд оролцсонд тооцно. Хурлын ирцийг хэлэлцэх асуудал бүрээр гаргах бөгөөд тухайн хэлэлцэх асуудалд санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг тухайн асуудал хэлэлцэхэд оролцсонд тооцно. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно.

### **Хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болох**

4.18. Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.

4.19. Хурлын ирц хүрээгүй тохиолдолд хурлыг хойшлуулах бөгөөд харин хэлэлцэх асуудал хэвээр байна. Хойшлогдсон хурлыг ажлын 20 өдрийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын 7-гоос доошгүй өдрийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.

4.20. Саналын эрхийн 20 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно.

4.21. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах, нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах, компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох, компанийн хэлбэрийг өөрчлөх, компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох, хувьцааг хуваах, нэгтгэх тухай асуудлыг хэлэлцэх хойшлогдсон хурал нь саналын эрхийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор хүчин төгөлдөр болно.

### **Бүртгэлийн өдөр**

4.22. Компанийн бүртгэлийн өдрийг ТУЗ хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь хурал хуралдуулах тухай шийдвэр гарсан өдрөөс өмнө байж болохгүй.

### **Санал авах хуудас, түүнийг хүчинтэйд тооцох**

4.23. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар саналыг санал авах хуудсаар авч болно. Энэ тухай ТУЗ хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрт тусгана.

4.24. Санал авах хуудасны агуулгыг ТУЗ хурал хуралдуулах тухай шийдвэрт тусгана. Санал авах хуудсанд Компанийн оноосон нэр, хурал хийх газар, өдөр, цаг, хувьцаа эзэмшигчдийн нэр, эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо хэмжээ, санал хураалтаар шийдвэрлэх асуудлын нэр, хурлаас хэлэлцэх асуудал бүрээр гарах шийдвэрийн тесел зэргийг тусгана.

4.25. Санал авах хуудсанд (ТУЗ болон Хяналтын зөвлөлийн гишүүнийг сонгохоос бусад тохиолдолд) санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг тэмдэглэсэн тохиолдолд хүчинтэй байна. Санал авах хуудсыг хурал зарласан өдрөөс эхлэн тухайн асуудлыг хэлэлцэж дуусах хүртэлх хугацаанд авна.

### **Цахим хэлбэрээр санал авах**

4.26. Компани цахимаар санал авах цахим програмыг хөгжүүлж, ашиглах талаар зохих туршлага бүхий мэдээллийн технологийн компанийтай үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, санал хураалтыг цахим хэлбэрээр явуулж болно. Энэ тохиолдолд хуралд оролцогчийн системд бүртгэх, түүний саналыг авах, ирцийн мэдээ болон авсан саналын дүнг өөрчлөх боломжгүйгээр, үнэн зөв илэрхийлэх боломжтой програмыг бүтээх үүргийг мэдээллийн технологийн компани хүлээн. Түүнчлэн мэдээллийн технологийн компани нь энэхүү үүргээ баталгаажуулсан албан бичгийг компанийд хүлээлгэж өгнө.

### **Хурлын зардал, хурлын тэмдэглэл**

4.27. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдох зардлыг компани бүрэн хариуцна.

4.28. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэр гарах бөгөөд хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор хурлын тэмдэглэлийг албажуулж, хурлын дарга гарын үсэг зурах бөгөөд хурлын дарга тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцна.

4.29. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд тусгах мэдээлэл, санал хураалтын дүнг зарпах болон тэмдэглэлтэй холбоотой бусад харилцааг Компанийн тухай хуульд зааснаар зохицуулна.

**ТАВДУГААР БҮЛЭГ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

- 5.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна.
- 5.2. ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, чиг үүрэг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг зэргийг Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-аар тогтоох бөгөөд уг журмыг ТУЗ батлан мөрдүүлнэ.  
/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтооолоор нэмэлт оруулсан/
- 5.3. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 4 нь хараат бус гишүүн байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтооолоор өөрчлөн найруулсан/
- 5.4. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байх бөгөөд ТУЗ-ийн гишүүнийг нэг удаа улируулан томилж болно.  
/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтооолоор өөрчлөн найруулсан/
- 5.5. ТУЗ-ийн гишүүнд урамшуулал олгож болох бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно. Урамшуулалтай холбоотой бусад харилцааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.
- 5.6. Удаан хугацаагаар үргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл ТУЗ түр томилж болно. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох үндэслэлийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

#### **ТУЗ-ийн бүрэн эрх**

- 5.7. ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 5.7.1. компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, компанийн бизнес төлөвлөгөөг батлах;
  - 5.7.2. хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
  - 5.7.3. хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалтыг гаргах, бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
  - 5.7.4. компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
  - 5.7.5. компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үnэт цаас гаргах;
  - 5.7.6. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
  - 5.7.7. өөрийн гаргасан хувьцаа, бусад үnэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;
  - 5.7.8. компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;
  - 5.7.9. компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
  - 5.7.10. аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
  - 5.7.11. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайллангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
  - 5.7.12. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
  - 5.7.13. компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
  - 5.7.14. компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
  - 5.7.15. хуульд заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
  - 5.7.16. сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
  - 5.7.17. ногдол ашгийн хэмжээг тогтоож, төлөх журмыг батлах;
  - 5.7.18. байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг батлах;



5.7.19. Компанийн шинээр худалдаж авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгөтэй холбогдох асуудлыг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

5.7.20. Брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компанийг гишүүнээр элсүүлэх, гишүүнээс хасах;

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны ... сарын ...өдрийн... дугаар тогтоолоор нэмж оруулсан/

5.7.21. эрх бүхий албан тушаалтны компанид учруулсан хөхирлын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор хассан/

5.7.22. Арилжаа эрхлэх байгууллагын Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмуудыг баталж, нийтэд мэдээлэх;

5.7.23. Өөрийгөө зохицуулах байгууллагын Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан дүрэм, журмуудыг баталж мөрдүүлэх;

5.7.24. Дүрмийн 5.7.22-т заасан дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээг тогтоох;

5.7.25. ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Хяналтын зөвлөлөөс ирүүлсэн санал, хүсэлтийг зохих журмын дагуу шийдвэрлэх;

5.7.26. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд заасан холбогдох журмыг баталж мөрдүүлэх;

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор нэмж оруулсан/

5.7.27. хууль болон компанийн дүрэмд заасан, эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал.

5.8. ТУЗ нь хууль тогтоомжид зөвхөн ТУЗ хэрэгжүүлэхээр зааснаас бусад бүрэн эрхээ Гүйцэтгэх удирдлагад хариуцуулан гүйцэтгүүлж болно.

#### **ТУЗ-ийн хурал**

5.9. ТУЗ-ийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн дарга, компанийн Гүйцэтгэх захирлын санаачилгаар, эсхүл ТУЗ-ийн дэргэдэх хорооны саналаар ээлжит бус хурал хуралдуулж болно.

5.10. ТУЗ-ийн хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүн бүр саналын нэг эрхтэй байна.

5.11. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болж, хуульд өөрөөр заагаагүй бол хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.

5.12. ТУЗ эчнэ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.

5.13. ТУЗ-ийн хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд ТУЗ-ийн хурлын дарга гарын үсэг зурна.

5.14. Компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдэд зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичиж хүргүүлэх бөгөөд тайланд дараах зүйлийг тусгана:

5.14.1. тайлангийн хугацаанд компанийн эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, бүтэц, зохион байгуулалт, түүний өөрчлөлт;

5.14.2. тайлангийн хугацаанд компанийн эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшуулалт удирдлагын зардлын хэмжээ;

5.14.3. хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.

### **ТУЗ-ийн хурлын тэмдэглэл**

- 5.15. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:
  - 5.15.1. хурал хуралдсан газар, өдөр, цаг;
  - 5.15.2. хуралд оролцсон гишүүд;
  - 5.15.3. хурлаар хэлэлцэн асуудал;
  - 5.15.4. санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон санал хураалтын дүн;
  - 5.15.5. гаргасан шийдвэр.
- 5.16. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүд гарын үсэг зурах бөгөөд тухайн тэмдэглэлийн үнэн зөвийг тухайн хурлын дарга хариуцна.
- 5.17. ТУЗ-ийн аль нэг гишүүн ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан тохиолдолд энэ тухай бичгээр тайлбар гаргана.
- 5.18. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг буруу хөтөлсөн нь тухайн хурлаас гаргасан шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

### **ТУЗ-ийн дарга**

- 5.19. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос тэдгээрийн дийлэнх олонхийн саналаар сонгоно.
- 5.20. Компанийн ТУЗ-ийн дарга нь бусад гишүүдтэй адил эрх эдлэхээс гадна ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих чиг үүргийг гүйцэтгэнэ.
- 5.21. ТУЗ-ийн даргын түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсон, эсхүл ТУЗ-ийн томилсон аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

### **ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэн сонгох**

- 5.22. Компанийн залгамж халааны бодлогын баримт бичгийг ТУЗ батална.
- 5.23. ТУЗ-ийн Цалин, урамшууллын болон Нэр дэвшүүлэх хороо нь Компанийн залгамж холбооны бодлогын дагуу ТУЗ-ийн гишүүнд Компанийн тухай хууль болон ТУЗ-ийн зохих журамд заасан шалгуурыг хангасан хүнийг сонгон шалгаруулж нэр дэвшүүлэн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлнэ.

### **ТУЗ-ийн хараат бус гишүүн**

- 5.24. ТУЗ нь хараат бус гишүүнтэй байна. ТУЗ-ийн хараат бус гишүүнд дараах шалгуурыг хангасан хүний нэрийг ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хороо дэвшүүлнэ:
  - 5.24.1. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй;
  - 5.24.2. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;
  - 5.24.3. төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;
  - 5.24.4. компанийн бизнесийн аливаа холбоогүй;
  - 5.24.5. хууль тогтоомжид заасан бусад шаардлага.
- 5.25. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь бусад гишүүдийн адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүргийг хүлээнэ:
  - 5.25.1. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сергээр нэлөөлөх эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцэж буй эсэхэд хяналт тавих, зөрчихеэс урьдчилан сэргийлэх, зөрчсөн тохиолдолд холбогдох этгээдэд тавьж шийдвэрлүүлэх, шаардлагыг эс биелүүлбэл ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах шаардлага хургүүлэх;

5.25.2. компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;

5.25.3. хувьцаа эзэмшигчдийн зэлжит хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн зарим шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулага хийх;

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтооолоор өөрчлөн найруулсан/

5.25.4. компанийн нөхцөл байдал, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигчдээс асуусан асуултанд хариу өгөх, тодруулга хийх;

5.25.5. компанийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг үр ашигтай зохион байгуулж байгаа эсэхэд хийсэн дотоод хяналтын албаны хяналт шалгалтын тайлантай нарийвчлан танилцах, шаардлагатай гэж үзвэл лавшруулан хянах, тухайн худалдан авах үйл ажиллагаа нь үр ашиггүй гэж үзвэл худалдан авалтыг зогсоох, цуцлах эрхийг эдлэнэ;

/Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтооолоор өөрчлөн найруулсан/

5.25.6. хуульд заасан бусад эрх, үүрэг.

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтооолоор өөрчлөн найруулсан/

5.26. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд дараах асуудлыг хэлэлцэхэд заавал оролцож саналаа өгнө. Үүнд:

5.26.1. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

5.26.2. санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;

5.26.3. Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох.

### **ТУЗ-ийн нарийн бичгийн дарга**

5.27. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно.

5.28. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх зэрэг ТУЗ-ийн журмаар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.29. Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах бөгөөд хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулна.

5.30. Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавина.

5.31. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлыг зохион байгуулна.

5.32. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эзгүйд түүний үүргийг орлох этгээдийг ТУЗ-ийн дарга томилно.

5.33. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг хариуцан зохицуулна.

### **ТУЗ-ийн дэргэдэх хороо**

5.34. ТУЗ нь дэргэдээ нь (а) Аудитын хороо; (б) Эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хороо; в) Нэр дэвшүүлэх хороо; г) Цалин, урамшууллын хороо гэсэн байнгын хороодтой байна.

5.35. Аудитын, Эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын, Нэр дэвшүүлэх, Цалин, урамшууллын хороодын гишүүдийн 2/3 (гуравны хоёр)-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.

5.36. Компанийн ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороо байгуулан ажиллуулж болно.

5.37. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:

5.37.1. компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

5.37.2. дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;

5.37.3. аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;

5.37.4. их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;

5.37.5. компанийн дүрэмд заасан болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

5.38. Эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:

5.38.1. компанийн эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалтын орчныг тодорхойлох;

5.38.2. компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг оновчтой удирдан чиглүүлэх;

5.38.3. компанийн эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, эрсдэлийн түвшинд хяналт тавих.

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

5.39. Нэр дэвшүүлэх хороо нь дараах чиглэлээр, дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулна:

5.39.1. компанийн залгамж холбооны бодлогыг боловсруулах, үйл ажиллагаандадаа чанд мөрдөж, хэрэгжүүлэх;

5.39.2. компанийн ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;

5.39.3. ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд энэ дүрэм болон Компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

5.39.4. компанийн залгамж холбооны бодлогын дагуу ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвших боломжтой этгээдийн судалгаа хийх, нөөцөд бүртгэх, бэлтгэх, шаардлагатай бол сонгон шалгаруулалт хийх, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;

5.39.5. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

5.39.6. гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;

5.39.7. ТУЗ-ийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтын ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;

5.39.8. Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.5-д заасан үндэслэлээр ТУЗ-ийн бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш турван жилийн хугацаанд тухайн

ТУЗ-ийн гишүүн байсан этгээдийн нэрийг аливаа хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүнд дэвшүүлэхээс татгалзах.

5.40. Цалин, урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:

5.40.1. компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтан, ажилтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

5.40.2. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;

5.40.3. компанийд мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх.

5.41. ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтооно.

### **ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН**

#### *Гүйцэтгэх захирал*

6.1. Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлаа ТУЗ-д тайлагнана.

6.2. Компанийн гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлэх бөгөөд уг этгээд компанийн Гүйцэтгэх захирал байна.

6.3. Гүйцэтгэх захирал нь холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам"-д заасан шалгуурыг тус тус хангаж холбогдох баримт бичгийг бүрдүүлэхээс гадна дараах шалгуурыг хангасан байна:

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/

6.3.1. банк, санхүү, эдийн засаг, хууль, эрх зүйн дээд боловсролтой, санхүүгийн салбарт таваас доошгүй жил эрх бүхий албан тушаалтнаар ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай;

6.3.2. зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй;

6.3.3. Төрийн эсрэг болон эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;

6.3.4. ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх;

6.3.5. хууль тогтоомж, гэрээнд заасан бусад шаардлага.

6.4. Компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд нь ТУЗ-ийн гишүүн байж болох бөгөөд ТУЗ-ийн дарга байхыг хориглоно.

6.5. Гүйцэтгэх удирдлага нь төрийн бөлөн хувийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ТУЗ-д орж, тэдгээрийн захиргаанд, төрийн бус байгууллага бөлөн шашны байгууллага, сангийн удирдах ажлыг хавсралт гүйцэтгэхийг хориглоно.

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор хассан/

6.6. Гүйцэтгэх захирал нь ээлжийн амралт эдлэх, гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, чөлөө авах, өвдөх тохиолдолд өөрийн эрх, үүргийг бүхэлд нь Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу эрх бүхий этгээдэд зөвхөн ТУЗ-ийн зөвшөөрлөөр шилжүүлнэ.

Түүнчлэн Гүйцэтгэх захирал тодорхой бүрэн эрхээ компанийн холбогдох албан тушаалтан, ажилтанд итгэмжлэн хариуцуулж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

6.7. Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтооолоор өөрчлөн найруулсан/

6.8. Гэрээнд Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин, шагнал, урамшуулал, хугацаа, гэрээ дүгнэх шалгуур зэрэг асуудлыг тусгасан байна.

6.9. Гүйцэтгэх захирал нь дор дурдсан эрх эдэлнэ:

- 6.9.1. Хедөлмөрийн тухай хуульд заасан ажил олгогчийн эрхийг хэрэгжүүлэх;
- 6.9.2. ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах;
- 6.9.3. эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргаж биелэлтийг нь хангуулах эрхтэй;
- 6.9.4. компанийн хөрөнгө захиран зарцуулах төлбөрийн баримтад гарын үсэг зурах;
- 6.9.5. компанид учруулсан хохирлыг төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах, эрүү, захиргаа, иргэний хэрэгт нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон оролцуулах;
- 6.9.6. ТУЗ-өөс баталсан зардал, бизнес төлөвлөгөөнд туссан бүтэц орон тооны хязгаарт багтаан үндсэн болон нэмэгдэл цалин, тэтгэмж, хөнгөлөлт, урамшууллын хэмжээг тогтоох;

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтооолоор өөрчлөн найруулсан/

- 6.9.7. ажилтнуудын ажил үүргийн хуваарийг тогтоох, ажилтныг ажилд авах, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах, дуусгавар болгох;
- 6.9.8. хууль тогтоомж, гэрээнд заасан бусад.

6.10. Гүйцэтгэх захирал нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

- 6.10.1. энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-өөс өгсөн үүрэг, чиглэл, шийдвэр, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, зохицуулагч байгууллагын шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулж ТУЗ-д тайлагнах;

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтооолоор өөрчлөн найруулсан/

- 6.10.2. компанийн стратегийн төлөвлөгөө болон эрсдэлийн удирдлага, зохистой засаглал, ёс зүйн хэм хэмжээний талаарх дотоод дүрэм, журам, заавар боловсруулж ТУЗ-д танилцуулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулж хангах;

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтооолоор өөрчлөн найруулсан/

- 6.10.3. компанийн үндсэн үйл ажиллагаа болон эрсдэлийн талаарх бүхий л заавар, журам болон стандартыг ажилтнуудаар мөрдүүлэн хэвшүүлэх, энэ талаар зохих гарын авлага болон зөвлөмжөөр хангах;

- 6.10.4. компанийн дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн жигд ажиллагааг ханган ажиллах, үр дүнг тогтмол үнэлэх;

- 6.10.5. дотоод хяналтын тогтолцоонд гажуудал үүссэн, эрсдэлийн удирдлагыг хангах талаар тогтоосон үйл ажиллагааны хязгаарлалт зөрчигдсэн бол холбогдох мэдээллийг цаг тухайд нь авч, зохих арга хэмжээг авах;

- 6.10.6. компанийн үйл ажиллагааны онцлог болон хүлээж болох эрсдэлийн нэр төрөлтэй уялдаатай удирдлагын мэдээллийн тогтолцоог бий болгох;

- 6.10.7. байгууллагын нууцад хамаарах зүйлийн жагсаалтыг батлах;
  - 6.10.8. компанийн санхүүгийн тайлан, тэнцэл, бусад төрлийн мэдээний үнэн зөвийг хариуцах;
  - 6.10.9. компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;
  - 6.10.10. мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах;
  - 6.10.11. компанийн ажилтнуудын хувьд өөрт ногдсон үүргээ аливаа ашиг сонирхлын зөрчилгүйгээр гүйцэтгэх нехцөлийг бүрдүүлэх;
  - 6.10.12. үүргээ гүйцэтгэх явцад олж авсан компани, үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагын болон хувь хүний нууцад хамаарах мэдээллийг өөрийн, эсхүл гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;
  - 6.10.13. хувийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй байх;
  - 6.10.14. Компанийн сайн засаглалын зарчмыг мөрдөж ажиллах;
- /Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор нэмж оруулсан/
- 6.10.15. өөрт нь болон өөрийн нэгдмэл сонирхол бүхий этгээдэд компанийтай бизнесийн харилцаанд орсон этгээдийн санхүүгийн үр дүнг сонирхох шалтгаан байгаа бол сонирхлын зөрчил байна гэж үзэж, энэ тухайгаа ТУЗ, түүний нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэх;
  - 6.10.16. хууль тогтоомж болон гэрээнд заасан бусад.

- 6.11. Гүйцэтгэх захирал нь үйл ажиллагааны стратеги, бизнес төлөвлөгөөнд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах талаар хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлээгүй, санаатай тасалдуулсан, энэхүү дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ёс зүйн зөрчил гаргасан, тэдгээрийг ноцтой зөрчсөн тохиолдолд ТУЗ түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх үндэслэл болно. Гүйцэтгэх захирал нь ажлаас чөлөөлөгдхөдөө хүндэтгэн үзэхээс бусад тохиолдолд үүрэгт ажлаа өөрийн биеэр биечлэн хүлээлгэн өгнө.
- /Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/
- 6.12. Гүйцэтгэх захиралд компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнд хүлээлгэх хариуцлагын талаар энэхүү дүрэмд заасан зохицуулалт нэгэн адил хамаарах бөгөөд ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан бол гэрээ дуусгавар болсонтой холбоотой үл өрсөлдөх, ажилтан урвуулахгүй байх үүрэгт хүлээнэ.

#### **Компанийн эрх бүхий албан тушаалтан, хүлээх хариуцлага**

- 6.13. Компанийн эрх бүхий албан тушаалтанд ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Газрын захирлууд, Ерөнхий нягтлан бодогч болон тэдгээртэй адилтгах албан тушаалтан хамаарна.

- 6.14. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:

- 6.14.1. Компанийн тухай хууль, энэхүү дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллахдаа Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-өөс өгсөн үүрэг чиглэлийг биелүүлэхэд гүйцэтгэх удирдлагад бүхий л байдлаар дэмжлэг үзүүлж, компанийн эрх ашигийг дээдлэх зарчмыг баримтална;

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

- 6.14.2. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг компанийд гаргаж өгнө;

- 6.14.3. компанийн нууцад хамаарах мэдээ, тайлан, гэрээ, баримт бичиг, материалыг бусдад дамжуулах, задруулахаас сэргийлэх бөгөөд хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;

- 6.14.4. шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаанд оролцоходоо холбогдох бүх баримт бичиг, мэдээллийг бүрэн судалж, ёс зүйн хэм хэмжээг сахин, шийдвэрийн үндэслэлд бүрэн итгэлтэй байх;



/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/

- 6.14.5. шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх;
- 6.14.6. өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх.

- 6.15. Эрх бүхий албан тушаалд нэр дэвших үедээ өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэrsийн жагсаалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарснаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэж байна.
- 6.16. Эрх бүхий албан тушаалтан нь Дүрмийн 6.14-т заасан үүргээ биелүүлээгүйн улмаас компанийд хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.
- 6.17. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг Компанийн тухай хууль, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан онцгой нөхцөл бүхий болон хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх бөгөөд боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.18. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанийтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 жилээс доошгүй хугацаанд компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахыг хориглоно.

## ДОЛДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

### Хяналтын зөвлөл

- 7.1. Компани нь хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн дагуу хамгаалах, хувьцаа эзэмшигчдээс компанийн үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдолыг хүлээн авч санал, дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий Хяналтын зөвлөлтэй байна.
- 7.2. Хяналтын зөвлөл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс бусад хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл бүхий 3 (гурав) гишүүний бүрэлдэхүүнтэй байна.
- 7.3. Хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 2 (хоёр) жил хүртэл байх бөгөөд Хяналтын зөвлөлийн гишүүнийг улируулан сонгохгүй.
- 7.4. Хяналтын зөвлөлийн гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгоно.
- 7.5. Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь дараах үндсэн шаардлагыг хангасан хувьцаа эзэмшигч иргэн байна. Үүнд:
  - 7.5.1. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5 (тав)-аас дээш хувийг эзэмшдэггүй байх;
  - 7.5.2. компанийтай сүүлийн 2 (хоёр) жилийн хугацаанд хөдөлмөрийн харилцаанд оролцоогүй байх;
  - 7.5.3. бусад арилжаа эрхлэх байгууллагын хувьцаа эзэмшигч, эсхүл түүний холбогдох этгээд бус байх;
  - 7.5.4. банк, санхүү, эрх зүй, эдийн засаг, бизнесийн чиглэлээр дээд боловсролтой, мэргэшсэн, мэргэжлээрээ 5 (тав)-аас доошгүй жил ажилласан мэдлэг, туршлагатай байх;
  - 7.5.5. зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өр төлбөргүй байх;
  - 7.5.6. Төрийн эсрэг болон эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй.
- 7.6. Энэхүү дүрмийн 7.5-д заасан шаардлагыг хангаж буй этгээдийг Хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгуулахаар тухайн этгээд өөрөө, эсхүл компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч бус хувьцаа эзэмшигч нэр дэвшүүлэх эрхтэй.
- 7.7. Нэр дэвшигчийн материалыг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо хүлээн авч хянаж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлнэ.

7.8. Нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан хүнийг Хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгоно.

7.9. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүд чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан компанийн зүгээс танилцуулсан болон бусад шугамаар олж авсан хуульд заасны дагуу компани, түүний харилцагч болон гуравдагч этгээдийн “нууц” гэж үзсэн аливаа мэдээлэл болон дотоод мэдээллийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх, шууд болон шууд бус байдлаар бусдад задруулахгүй байх, гуравдагч буюу хөндлөнгийн этгээдэд дамжуулахгүй байх үүрэгтэй.

7.10. Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно.

#### **Дотоод хяналт**

7.11. Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ өөрийн Аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

7.12. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос санал болгосноор Гүйцэтгэх захирлын томилсон Дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ.

7.13. Дотоод хяналтын алба нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү, нягтлан бодох бүртгэл, эрх зүйн мэдлэг, туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Гүйцэтгэх захирлын баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

7.14. Гүйцэтгэх захирлын зөвлөлийн хуралдаанаар Дотоод хяналтын албаны мэдээлэл, шалгалтын дүнг улирал бүр хэлэлцэн, холбогдох арга хэмжээг авна.

7.15. Дотоод хяналтын албаны ажилтан ажлын байранд хэзээ ч нэвтрэх, аливаа мэдээллийг шаардан гаргуулах эрхтэй байна.

#### **Хөндлөнгийн аудит**

7.16. Аудитын тухай хуульд заасны дагуу компанийн санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх хөндлөнгийн аудитын байгууллагыг ТУЗ сонгож, түүнтэй заавал гэрээ байгуулж ажиллуулна.

7.17. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална.

7.18. Дараах этгээдийг компанийн хөндлөнгийн Аудитоор сонгон ажиллуулахыг хориглоно:

7.18.1. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн болон нэгдмэл сонирхолтой компанийн эрх бүхий албан тушаалтан;

7.18.2. компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрх эзэмшдэг;

7.18.3. ТУЗ-өөс тухайн этгээд нь дотоод аудитороор ажиллахад харшилна гэж үзсэн үндэслэл бүхий бусад нөхцөл.

7.19. Аудитын байгууллагатай байгуулах гэрээнд компанийн болон аудитын байгууллагын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заасан байна.

7.20. Аудитын шалгалт нь ээлжит болон ээлжит бус байна.

7.21. Компанийн санхүүгийн жилийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит шалгалт хийнэ.

7.22. Ээлжит бус шалгалтыг ТУЗ, эсхүл нийт хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчдийн шаардлагаар хэдийд ч хийж болно.



7.23. Шалгалтын явцад эрх бүхий албан тушаалтан компани болон хувьцаа эзэмшигчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд төлөх бөгөөд бусад тохиолдолд компани өөрөө, эсхүл шаардлага тавьсан талууд хариуцна.

#### **Их хэмжээний хэлцэл**

7.24. Их хэмжээний хэлцэлд дараах хэлцлийг ойлгоно. Үүнд:

7.24.1. хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/;

7.24.2. компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг, эсхүл энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.

7.25. Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг ТУЗ-ийн саналын эрхтэй гишүүд санал нэгтгэйгэр гаргана.

7.26. ТУЗ их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтгэйгэр гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

7.27. Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ тогтооно.

7.28. Их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлохдоо ТУЗ нь Аудитын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг инфляцын /мөнгөний ханшийн уналт/ түвшинтэй уялдуулан шинэчлэн тогтоож болно.

#### **Сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийх хэлцэл**

7.29. Нэгдмэл сонирхолтой этгээд, түүнтэй хийх хэлцлийг тодорхойлох, компанийн үйл ажиллагаан дахь сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг тусад нь журмаар зохицуулна. Уг журмыг ТУЗ батална.

7.30. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад санал өгөх эрхгүй байна.

7.31. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар гаргана.

7.32. Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжийг хангах үүрэгтэй.

7.33. Компани тухайн тайлангийн хугацаанд байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн дүнгийн талаарх мэдээллийг тухайн жилийн тайланд тусган нийтэд мэдээлэх үүрэгтэй.

#### **НАЙМДУГААР БҮЛЭГ. МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛ**

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор нэмж оруулсан/

8.1. Бирж нь өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлын хүрээнд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд оролцогчдын хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий маргаан таслах зөвлөл /цаашид "Маргаан таслах зөвлөл" гэх-/тэй байх бөгөөд Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг Төлөөлөн удирдах зөвлөл батална.

8.2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд оролцогч нь биржийн арилжаатай холбоотой гомдолоо арилжаа хийгдсэнээс хойш 30 хоногийн дотор Маргаан таслах зөвлөлд гаргана.

8.3. Маргаан таслах зөвлөл гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор дараах шийдвэрийн аль нэгийт гаргана:

8.3.1. гомдлын шаардлагыг хангах;

8.3.2. гомдлын шаардлагыг хэрэгсэхгүй болгох;

8.3.3. гомдлын хүрээнд арилжааны шийдвэрт өөрчлөлт оруулах.

8.4. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд оролцогч нь Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. БУСАД

### *Үнэт цаас худалдах, эргүүлэн авах*

9.1. Компани давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг зохих хууль журамд заасны дагуу гаргаж болно.

9.2. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу худалдан авч болох бөгөөд энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

9.3. Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь худалдан авч болох бөгөөд харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджийн 25 хувиас хэтэрч болохгүй.

9.4. Компани нь үнэт цаас эргүүлэн худалдаж авахдаа худалдаж байгаа этгээдтэй тохиролцсоны дагуу түүний төлберийг бэлэн мөнгө, үнэт цаас буюу эд хөрөнгийн бусад хэлбэрээр хийж болно.

### *Ногдол ашиг хуваарилан олгох*

9.5. ТУЗ нь ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана.

9.6. Ижил төрлийн хувьцаа бүрийн хувьд нэгж хувьцааны ногдол ашгийн дүн нь хувьцаа бүрийн хувьд адил байна.

9.7. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

9.8. Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн эзлжит хуралд тайлагнах үүрэгтэй.

9.9. Компани нь хууль тогтоомжид заасан бүх нөхцөл биелэгдсэн тохиолдолд энгийн хувьцаанд хамаарах ногдол ашгийг хуваарилж болно.

9.10. Компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилна. Энэ хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл компани ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй.

9.11. Хуваарилахаар шийдвэрлэсэн ногдол ашгийг ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигч бүрээр түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэж хадгалах бөгөөд компани хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох үүрэгтэй.

9.12. Компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

9.13. ТУЗ нь ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд заавал тайлагнана.

9.14. Хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах буюу бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн

хувьцааг бусдад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хувьцааны хуучин эзэмшигчид үлдэнэ.

9.15. ТУЗ нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, энэ дүрэмд нийцүүлэн Ногдол ашгийн бодлого батална.

**Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлан**

9.16. Компанийн санхүүгийн жилийн эхлэх, дуусах хугацаа нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл байна.

9.17. Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон эрх бүхий байгууллагын журмаар тогтоосон мэдээ, тайлангийн үнэн зөвийг компанийн Гүйцэтгэх захирал хариуцна.

9.18. Санхүүгийн мэдээллийн үнэн зөвийг Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан хамтран хариуцна.

9.19. ТУЗ нь компанийн санхүүгийн тайлангийн талаарх хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.

9.20. Компани Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон нэмэлт, мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт тогтоосон хугацаанд нь хүргүүлж байх үүрэгтэй.

**Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах**

9.21. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хууль, энэ дүрэмд заасны дагуу шийдвэрлэнэ.

9.22. Компанийг дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хуульд заасан журмаар татан буулганы:

9.22.1. Компанийн үйл ажиллагаа алдагдалтай байгаагаас цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;

9.22.2. ТУЗ нь компанийг татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараа компанийд үлдэх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхи зөвшөөрсөн;

9.22.3. Хуульд заасан бусад үндэслэлээр.

**Дүрэм хүчин төгөлдөр болох**

9.23. Энэхүү дүрэм нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталж, улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

9.24. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батлах бөгөөд тухайн нэмэлт, өөрчлөлт нь улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

-----оо-----